

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<p>“Зоонозын өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг эмч мэргэжилтнүүдийн туршлага, чадавхад үндэслэн, судалгаа, шинжилгээ, нотолгоонд тулгуурлан, оновчтой бүтэц, эрх зүйн орчин бүрдүүлэн халдварын эрсдэлийг бууруулах замаар хүн амыг өвчлөл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх”</p>							
<p>Зорилт 1. Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх</p>							
1.1	<p>Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 тоот албан даалгавар Тусламж, үйлчилгээнд чанарын дотоод хяналтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.</p>	-	<p>Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь</p>	<p>7 зорилтын 25 арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан.</p>	<p>Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.</p>	<p>Байгууллагын тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах, эрсдэлийг бууруулах 2023 оны 5 бүлэг 26 зүйл бүхий төлөвлөгөөг төвийн захирлаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023 оны төвийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийг тогтоох дэмжлэгт хяналт хийх хуваарийн дагуу:</p> <ol style="list-style-type: none"> 1. Лабораторийн хог хаягдлын менежментийн чанар, аюулгүй байдалд үнэлгээ хийх ажлын удирдамжийг төвийн захирлаар батлуулан хяналт хийж, үр дүнг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн амь сорьцын лабораториудын биоаюулгүй ажиллагааны нөхцөл сайжирч, хатуу хог хаягдал халдваргүйжүүлэх, боловсруулах үйл ажиллагаа боловсронгуй болсон дүгнэлт гарсан. 2. Амь сорьцын лабораторид засвар үйлчилгээний үед чанар, аюулгүй байдлын хяналтыг тогтмолжуулсан. Засвар үйлчилгээний хяналт тавьсан талаарх илтгэх хуудас бичигдэж, амь сорьцын лабораториудын биоаюулгүй ажиллагааны 	100

					<p>нөхцөл сайжирч, хатуу хог хаягдал халдваргүйжүүлэх, боловсруулах үйл ажиллагаа боловсронгуй болсон.</p> <p>3. НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр “Эмнэлгийн хатуу хог хаягдлыг халдваргүйжүүлэн боловсруулах” Newster NW15 тоног төхөөрөмжийг суурилуулах, холбогдох засвар үйлчилгээг хийснээр хог хаягдлын менежмент боловсронгуй болж биоаюулгүй ажиллагааны нөхцөл сайжирсан.</p> <p>4. Төвийн Ариутгал халдваргүйтгэл био үйлдвэрлэлийн алба, Чанар, аюулгүй байдал, хяналт үнэлгээний албаны Эрүүл зүйн чанарын хяналтын лабораторид ашиглагдаж буй нийт 27 тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулж батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.</p> <p>5. “Лабораторийн хэрэглээнд ашиглагдаж буй хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээ, бүрэн бүтэн байдал, хангалт, чанар үнэлгээ”-ний удирдамжийн дагуу дотоод хяналт хийж, Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн цаашид хангалт хийхдээ чанарын менежер, дэглэмийн багт танилцуулан чанарын шаардлага хангасан хувцас хэрэглэлээр ханган ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.</p>
				-	<p>1. Тархвар судлалын заалтаар хийгддэг зоонозын өвчний эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх удирдамжийг батлуулан хяналт, зөвлөн туслах үйлчилгээг аймаг, нийслэлийн ЗӨСТ болон ЗӨСҮТ-ийн мэргэжилтнүүд, удирдлагаас бүрдсэн баг орон нутагт томилолтоор ажиллах хугацаандаа аймаг, дүүрэг, сум бүрийн дархлаажуулалтын нэгжид дэмжлэгт хяналт</p>

1.2	<p>Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01, 02 тоот албан даалгавар, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал</p> <p>Тархвар судлалын заалтаар хийгддэг зоонозын өвчний эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийнэ.</p>	Олон улсын төсөл, хөтөлбөр	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь		4 байгууллагын үйл ажиллагаанд зөвлөмж өгч, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна.	<p>хийж, зөвлөгөө, зөвлөмжийг өгч ажилласан. Архангай, Баян-Өлгий, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл, Увс, Сэлэнгэ аймгуудын БОЭТ, НЭ-ийн Яаралтай түргэн тусламжийн тасаг, Өрхийн эрүүл мэндийн төв, сумын Эрүүл мэндийн төвүүд зэрэг нийт 63 дархлаажуулалтын нэгжид галзуу өвчний эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт үнэлгээ хийсэн.</p> <p>2. ДЭМБ-ын санхүүжилтээр Зүүн болон Төвийн бүсийн ЗӨСТ-гүй аймгуудын ЭМГ, Өрх сумын ЭМТ-үүдэд дэмжлэгт хяналт хийж ажилласан. Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын Эрүүл мэндийн газар болон Өрхийн ЭМТ-ийн нийт 26 дархлаажуулалтын нэгжид тархвар судлалын заалтаар хийгддэг зоонозын өвчний дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Хяналт үнэлгээгээр зоонозын өвчний дархлаажуулалтын зохион байгуулалт, вакцин, хүйтэн хэлхээ, зарцуулалт, хадгалалтын байдлыг үнэлэн зөвлөмж, мэргэжил аргазүйгээр хангаж, хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт хийж ажилласан. Зоонозын өвчний дархлаажуулалт сургалтыг аймаг сум, Өрхийн ЭМТ, ЭМГ, БОЭТ, НЭ-ийн дархлаажуулалт хариуцсан эмч, мэргэжилтэн, халдвартын тасгийн эмч, сувилагч, вакциначууд зэрэг нийт 274 эмч, сувилагч нар хамрагдсан байна.</p>	100
1.3	<p>Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 тоот албан даалгавар</p> <p>Байгууллагын үйлчилгээний соёлын удирдамж /заавар/-ийг</p>	-	Батлагдсан удирдамж, Үйлчилгээний соёлтой холбоотой гарсан гомдлын тоо	-	Батлагдсан үйлчилгээний соёлын удирдамж /заавар/-ийг мөрдөж, гомдол	<p>Байгууллагын соёлыг сайжруулах ажлын удирдамж боловсруулан Төвийн захирлаар батлуулан удирдамжийн хэрэгжилтийг 2023 онд 100% ханган ажилласан. Уг удирдамжийн хүрээнд байгууллагын үйлчилгээний соёлыг хэвшүүлэх, ажилчдын хувийн харилцааны соёлыг дээшлүүлэн,</p>	100

	боловсруулан баталж, мөрдөнө.				санал гаргалгүй ажилласан байна.	ээрэг хандлага төлөвшүүлж, ажлын хариуцлага, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, хамт олны нэгдмэл байдлыг ханган, багаар ажиллах чадварыг сайжруулж, байгууллага нэгжийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор 9 үйл ажиллагааг хэрэгжүүллээ.	
1.4	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/464 дүгээр тушаал Зоонозын өвчний оношилгоо, эмчилгээний зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулна.	-	Батлагдсан зааврын тоо	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/160 дугаар тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.	Зоонозын 12 өвчний оношилгоо, эмчилгээний зааврыг шинээр батлуулан мөрдөж ажилласан байна.	Тарваган тахал, хачигт энцефалит, хачигт риккетсиоз, хачигт боррелиоз, галзуу, шүлхий, холер, хумхаа, боом бэтэг шинэчлэн, хулгана тахал, листериоз, анаплазмоз, эрлихиоз, ку чичрэг оношилгоо, эмчилгээ, тандалтын заавар шинээр боловсруулж, мэргэжилтнүүдээрээ хэлэлцэж зөвлөхүүдээс санал аван мэргэжлийн зөвлөлөөр хянуулахаар өгөөд байна.	70
1.5	МУХТЖҮЧ 2.2.1; ЗГҮАХ 1.1.3.1 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдлын үнэлгээ хийж, нөөцийг бүрдүүлнэ.	-	Нөөцийн хэмжээ	Агуулахын барилга ашиглалтад бүрэн орж үйл ажиллагаа эхэлсэн.	Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед 1-3 сарын нөөц бүрдүүлсэн байна.	1. Эрүүл мэндийн салбарын НЭМ-ийн ноцтой байдлын нөөцийн агуулахын үйл ажиллагааны хүрээнд ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу “Монгол эм импекс” ХХК-ийн агуулахад хадгалан түгээж байсан улсын нөөцийн эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, оношлуур, тоног төхөөрөмжийг тус төвийн нөөцийн агуулахад татан байршуулах үйл ажиллагааг 2022 оны 12 дугаар сарын 19-21-ний өдрийн хооронд ЭМЯ, ЗӨСҮТ-ийн хамтарсан ажлын хэсэг зохион байгуулсан. Агуулахын нөөцөд ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 01 сарын 05-ны өдрийн А/04 дүгээр Тооллогын комисс томилох тухай тушаалаар томилогдсон ажлын хэсгийн гишүүд тооллого хийж, эм бараа, материалын хугацаа, бүрэн бүтэн байдал, хадгалалтын байдалд хяналт хийсэн. 2. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед хариу арга хэмжээний бэлэн байдлыг	100

						<p>хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулахад шаардлагатай эрүүл мэндийн салбарын нөөцийн жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын А/46 дугаар Ажлын хэсэг байгуулах тухай тушаалаар 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг шаардлагатай нөөцийн жагсаалтын судалгаанд тулгуурлан боловсруулж батлуулсан. Эрүүл мэндийн сайдын А/211 дүгээр Жагсаалт батлах тухай тушаалаар болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн салбарын нөөцөд байх эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйтгэлийн бодис, оношлуурын жагсаалтыг нэгдүгээр, эрүүл мэндийн байгууллагын нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйтгэлийн бодис, оношлуурын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлуулан нөөцийг бүрдүүлэхэд эрх зүйн орчныг бий болгосон.</p> <p>ЗӨСҮТ-ийн дэргэдэх Эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахад эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйтгэлийн бодис, оношлуурын 1 сарын нөөцтэй байна.</p>	
1.6	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 6.5.1 Лабораторийн үйл ажиллагаанд ISO15189 стандартыг нэвтрүүлж, итгэмжлэгдэнэ.</p>	-	Гэрчилгээ	Урьдчилсан үнэлгээнд хамрагдсан.	Стандартын гэрчилгээ авсан байна.	<p>1.Үндэсний Итгэмжлэлийн Төвийн Үнэлгээний багаас зохион байгуулсан MNS ISO 15189:2015 лабораторийн магадлан итгэмжлэлийн үнэлгээнд бэлтгэн хамрагдаж, холбогдох баримт бичгийн болон үйл ажиллагааны үзлэг шалгалтад амжилттай хамрагдан үл тохирол гараагүй. Итгэмжлэлийн албаны мэргэжилтнүүдийн зөвлөсний дагуу холбогдох баримт бичигт засварлан сайжруулж тухай бүр нэмэлт мэдээллийг боловсруулж хүргүүлсэн.</p>	100

						<p>2.MNS ISO 15189:2015 итгэмжлэлийн холбогдох баримт бичгийн бүрдүүлэлт хийж, зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний биелэлт гарган өгсөн. Итгэмжлэлийн хороонд тайлан хэлэлцэгдэж Техникийн хорооны хурлаар дэмжигдэж тоот тушаалаар итгэмжлэгдсэн.</p> <p>3."MNS ISO 15189:2015 ерөнхий тайлбар, хэрэгжүүлэх арга зам" ажлын байрны сургалтыг 14 аймгийн ЗӨСТ-ийн 188 эмч, мэргэжилтнүүдэд амжилттай зохион байгуулсан. Өвөрхангай, Багануурын ЗӨСТ-ийг MNS ISO 15189:2015 лабораторийн магадлан итгэмжлэлд хамруулах ажлын хүрээнд баримт бичгийн боловсруулалт, ажлын байрны үнэлгээг хийж, бэлтгэл ажлыг хангаж эхлээд байна.</p>	
1.7	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 6.5.2 Орон нутгийн ЗӨСТ-ийн лабораторийн оношилгооны чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.</p>	Азийн Хөгжлийн банк	Сургалтад хамрагдсан 14 аймгийн ЗӨСТ-ийн ажилтны хувь	-	<p>14 аймгийн ЗӨСТ-ийн лабораторийн 56 ажилтныг сургалтад хамруулж QMobile- аар оношилгоо хийх чадавхыг сайжруулсан байна.</p>	<p>Азийн хөгжлийн банк, Ядуурлыг бууруулах Японы улсын санхүүжилтээр хэрэгжиж буй МОН-9218 төслийн хүрээнд “Нийслэл, аймгийн Зоонозын өвчин судлалын төвүүдэд молекул биологийн оношилгоог нэвтрүүлэх ажлын байран дахь сургалт”-ыг тус тус зохион байгуулж 14 аймгийн ЗӨСТ-ийн нийт 226 эмч, мэргэжилтнийг ажлын байранд нь сургалтад хамруулсан. Уг төслийн хүрээнд хээрийн тандалт судалгааны багц тоног төхөөрөмж, лаборатори болон ариутгал халдваргүйтгэлийн багцаар 5 салбар төвийг хангасан.</p>	100
1.8	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 6.5.2 6 аймгийн ЗӨСТ-ийн лабораторийг молекул биологийн шинжилгээ хийх иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангана.</p>	Азийн Хөгжлийн банк	Молекул биологийн шинжилгээний сорьцын тоо	-	<p>6 аймгийн ЗӨСТ-ийн лаборатори молекул биологийн оношилгоог тогтмол хийдэг болсон байна.</p>	<p>- Тухайн сургалтын үр дүнд орон нутагт ПГУ шинжилгээг хийж гүйцэтгэж, 2023 онд Нийслэл, Увс, Ховд, Завхан, Баянхонгор, Өмнөговь, Өвөрхангай аймгийн ЗӨСТ-д молекул биологийн шинжилгээг нэвтрүүлснээр нийт 1175 сорьцод ПГУ шинжилгээ хийж 252 сорьц эерэг дүнтэй тодорхойлогдож, лавлагаа шинжилгээгээр онош 100 хувь баталгааждаг байна.</p>	100

						<p>- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр 14 салбар төвд 250.000.000\$-ийн өртөг бүхий Молекул биологийн иж бүрэн лабораторийн тоног төхөөрөмжийг нийлүүлж хүлээлгэн өгснөөр зоонозын өвчний үеийн онош зүйн тусламж, үйлчилгээний хүчин чадал, био аюулгүй ажиллагааны үзүүлэлт нэмэгдсэн.</p> <p>- Азийн хөгжлийн банк, Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр 11 салбар төвд бодит цагийн ПГУ-ын машиныг нийлүүлснээр 14 салбар төв 100% б.ц ПГУ-ын машинаар хангагдаж, цаашид орон нутагт оношзүйн тусламж, үйлчилгээг бүрэн зохион байгуулах боломж, техник, тоног төхөөрөмж, хүний нөөцийн хувьд бэлтгэгдээд байна.</p>	
1.9	<p>МУХТЖҮЧ 2.2.1; ЗГҮАХ 1.1.3; Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.2.1</p> <p>Дорноговь, Дорнод, Дархан-Уул, Төв аймагт ЗӨСТ, хил дагуух 12 боомтод тандалтын нэгж байгуулах хэрэгцээ, шаардлага, техник эдийн засгийн үндэслэл, тооцооллыг боловсруулна.</p>	-	Салбар ЗӨСТ байгуулах шийдвэр	<p>4 аймагт шинээр ЗӨСТ байгуулах, 12 хилийн боомтод тандалтын нэгж байгуулах тооцоолол үндэслэл, эдийн засаг хөрөнгө оруулалтын тооцоолол, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан ЭМЯ-нд хүргүүлсэн.</p>	<p>Дорноговь, Дорнод, Дархан-Уул, Төв аймагт ЗӨСТ, хил дагуух 12 боомтод тандалтын нэгж байгуулах саналыг ЭМЯ-нд хүргүүлэн шийдвэрлүүлсэн байна.</p>	<p>1. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 1.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 1.1.3.2-т заасан арга хэмжээний хүрээнд 2021-2023 онд “6 аймагт Зоонозын өвчин судлалын төв (ЗӨСТ)-ийг, хилийн 24 боомтод тандалтын нэгж байгуулах”-аар тусгагдсан. Уг ажлын хүрээнд 4 аймагт шинээр ЗӨСТ байгуулах, 5 аймгийн ЗӨСТ-ийн барилгыг шинээр бариулах, 12 хилийн боомтод тандалтын нэгж байгуулах тооцоолол үндэслэл, эдийн засаг хөрөнгө оруулалтын тооцоолол, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар дэмжүүлэн 15 яамнаас санал авч Засгийн газрын хэрэг эрхлэх газарт Монгол Улсын Засгийн газрын тогтоол гаргуулахаар хүсэлтийг хүргүүлсэн. 2022 оны 11 дүгээр сарын</p>	100

						<p>08-ны өдрийн 1а/5053 тоот албан бичгээр ЭМЯ-наас ЗГХЭГ хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийг хүлээж байна.</p> <p>2. Нэгж байгуулах бэлтгэл ажлын хүрээнд тус төвөөс Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний тасралтгүй байдал, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, халдварт өвчний дэгдэлтийн бэлэн байдалд зориулж, Өмнөговь аймгийн Гашуун сухайт, Шивээ хүрэн, Дорноговь аймгийн Ханги, Сүхбаатар аймгийн Бичигт зэрэг боомтуудад дээрх үйл ажиллагаа хэрэгжиж хэвийн болох хүртэл түр хугацаагаар НҮБ-ын Хүүхдийн сангийн хандиваар ирсэн Зөөврийн эмнэлэг, ариун цэврийн байгууламжийг байршуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус зөөврийн эмнэлэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бүрэн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, сэжигтэй өвчтөнийг тусгаарлах өрөөтэй, бие даасан цахилгаан, сантехникийн дэд бүтэцтэй, үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд зориулсан ариун цэврийн өрөөтэй байгууламжууд юм.</p>	
Зорилт 2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед авах хариу арга хэмжээний бэлэн байдал, чадавхийг сайжруулах							
2.1	Зоонозын өвчний тохиолдол бүртгэгдсэн үед тухай бүр эрсдэлийн үнэлгээ хийнэ.	-	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	2022 онд зоонозын өвчний сэжигтэй 5 тохиолдолд эрсдэлийн үнэлгээ хийж, эргэн мэдээлэл, зөвлөмжөөр ханган ажилласан.	Эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг холбогдох газарт хүргүүлж, голомтыг цомтгох арга хэмжээг авсан байна.	<p>Зоонозын халдварт өвчний тохиолдлын эрсдэлийн үнэлгээ 17 удаа хийхэд бага эрсдэлтэй 8 (галзуу 4, тарваган тахал 4), дунд эрсдэлтэй 8 (тарваган тахал), өндөр эрсдэлтэй 1 (тарваган тахал) үнэлэгдэж, эргэн мэдээлж, зөвлөмжөөр ханган ажиллав. Галзуу өвчний эрсдэлийн үнэлгээ 4 удаа Сүхбаатар, Баян-Өлгий, Дундговь, Орхон аймгуудаас бүртгэгдсэн тохиолдолд хийхэд бага эрсдэлтэй, тарваган тахал өвчний эрсдэлийн үнэлгээ 13 удаа Говь-Алтай, Увс, Баянхонгор, Хэнтий, Завхан аймгуудаар бүртгэгдсэн тохиолдолд үнэлгээ хийхэд 4 тохиолдол бага, 8 тохиолдол дунд, 1 тохиолдол өндөр эрсдэлтэй</p>	100

						үнэлэгдэж, эрсдэлийн түвшинд тохирсон хариу арга хэмжээний зөвлөмж боловсруулан тухай бүр хүргүүлж, хариу арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.	
2.2	<p>“Алсын хараа”- 2050; МУХТЖҮЧ 2.2.1; 2.2.10; ЗГҮАХ 1.1.3.1</p> <p>Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, урвалж оношлуурыг гаалиас авахад шаардлагатай тусгай зөвшөөрөл авна.</p>	500.0 мян.төг (Улсын төсөв)	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	-	Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас газраас тусгай зөвшөөрлийг авсан байна.	<p>1. Эрүүл мэндийн яам, Монгол эм импекс концерн ХХК-тай байгуулсан гэрээний дагуу Олон улсын байгууллагаас ирсэн /НҮБ Хүүхдийн сан, ДЭМБ/ эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг МЭИК ХХК агаараар болон төмөр замаар ирсэн барааг гаалийн бүрдүүлэлт хийж татвар тооцоог хийж гаалиас хүлээн авч Эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахад хүлээлгэн өгч ажиллаж байна. Хил гаалиас бараа хүлээн авахад Эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахад ЭМЯ-наас эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас биологийн идэвхт бүтээгдэхүүн, хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис импортлох тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай байгаа тул Эрүүл мэндийн яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт 2023 оны 03-р сард холбогдох материалыг албан бичгийн хамт хүргүүлсэн.</p> <p>2. Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/100 дугаар Журам шинэчлэн батлах тухай тушаал гарч тусгай зөвшөөрлийн материал хүлээн авч эхэлсэн. ЭМЯ-нд өгсөн Тоног төхөөрөмж импортлох тусгай зөвшөөрлийн төсөл дэмжигдэж, ажлын байранд шинжээч ирж танилцаж дүгнэлт гарч тусгай зөвшөөрлийн</p>	100

						<p>комиссын хурлаар хэлэлцэгдэж тусгай зөвшөөрөл авсан. Мөн ЭЭХХЗГ-аас Тусгай зөвшөөрлийн төсөлд шинжээч томилогдож ажлын байранд шинжээч ирж танилцаж дүгнэлт тус тус гарч комиссын 2023 оны 08 дугаар сарын хурлаар хэлэлцэгдэж эмнэлгийн багаж тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх, эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөл тус тус авсан.</p>	
2.3	<p>ЗГҮАХ 1.1.4.1 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулахад шаардлагатай эрүүл мэндийн салбарын нөөцийн жагсаалт боловсруулна.</p>	-	Шинэчлэн батлагдсан жагсаалт	<p>Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2020 оны 163/А/603 дугаар тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.</p>	Жагсаалт шинэчлэн батлагдсан байна.	<p>1. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулахад шаардлагатай эрүүл мэндийн салбарын нөөцийн жагсаалт боловсруулах "Ажлын хэсэг байгуулах тухай" Эрүүл мэндийн сайдын А/46 дугаар тушаал гарч, 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдсон. Ажлын хэсгийг ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын Стратеги удирдлагын хэлтсийн даргаар ахалсан ЭМЯ-наас 4 мэргэжилтэн, ЭЭХХЗГ-аас 2, ЗӨСҮТ 2, ХӨСҮТ 2 мэргэжилтэн тус тус орж ажилласан. Ажлын хэсэг 2 удаа хуралдаж байгууллагуудын санал, мэргэжлийн салбар зөвлөлүүдээс санал авч ажилласан. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, тухайн арга хэмжээг шуурхай зохион байгуулах үйл ажиллагаанд шаардлагатай зүйлсийн жагсаалтыг:</p> <ul style="list-style-type: none"> - Эм 47 нэр төрөл - Эмнэлгийн хэрэгсэл – 26 нэр төрөл - Хувийн хамгаалах хэрэгсэл - 11 нэр төрөл - Тоног төхөөрөмж -18 нэр төрөл - Ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис 6 нэр төрлийг тус тус төсвийн 	100

						<p>хамт гаргаж ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн газарт жагсаалт, төсвийн төсөөллийг урьдчилсан байдлаар танилцуулсан. Уг жагсаалтыг боловсруулахдаа ЗӨСҮТ-ийн дэргэдэх Эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахын хүчин чадлыг түшиглэн тооцоолж хийсэн бөгөөд агуулахын зай талбайн хэмжээ, 4 шатлалаар буюу багийн эмчийн, сум, тосгоны Эрүүл мэндийн төв, аймаг, нийслэл, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг гэсэн шатлалаар боловсруулсан.</p> <p>2. Мэргэжлийн салбар зөвлөлүүдээс саналыг авч нэгтгэн Эрүүл мэндийн сайдын А/211 дүгээр Жагсаалт батлах тухай тушаалаар баталсан. Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн салбарын нөөцөд байх эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйтгэлийн бодис, оношлуурын жагсаалтыг нэгдүгээр, эрүүл мэндийн байгууллагын нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйтгэлийн бодис, оношлуурын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлуулсан.</p>	
2.4	“ОХУ, Монгол Улсын хил орчмын бүс нутагт хачигт халдварын лабораторийн оношилгоо, яаралтай урьдчилан сэргийлэх” онолын болон дадлагажуулах сургалт зохион байгуулна.	Олон улсын төсөл, хөтөлбөр		-	55 мэргэжилтэн “Хачигт халдварын лабораторийн оношилгоо, яаралтай урьдчилан сэргийлэх” онолын болон дадлагажуулах	<p>1. ОХУ, Монгол Улсын хамтын ажиллагааны хүрээнд худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны талаар 2 улсын Засгийн газар хоорондын комиссын 25 дугаар хуралдаанаар Сэлэнгэ аймагт ОХУ-ын Эрхүү хотын “Гэр бүлийн эрүүл мэнд нөхөн үржихүйн төв”-тэй хамтран тус аймагт “Хачигт халдварын оношилгоо урьдчилан сэргийлэлтийн төв”-ийг байгуулах санамж бичигт гарын үсэг зурсан.</p> <p>2. Хамтын ажиллагааны хүрээнд Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан “Выездная</p>	100

			Сургалтад хамрагдсан хүний тоо		сургалтад хамрагдсан байна.	международная школа-семинар «Лабораторная диагностика и экстренная профилактика актуальных клещевых инфекций на приграничных территориях России и Монголии»-2023” сургалтад 3 мэргэжилтэн хамрагдан, “Хачгаар дамжих халдварт өвчний лабораторийн оношилгоо, цаашдын чиглэл” сэдэвт танилцуулга хийсэн. Уг сургалтад 35 байгууллагын 140 гаруй мэргэжилтэн хамрагдаж, хачигт халдварын тандалт, оношилгоо, эмнэлзүйн чиглэлээр олон улсад мөрдөгдөж буй арга зүй, орчин үеийн технологид суралцсан.	
2.5	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.1.3 “Нэг эрүүл мэнд - Зооноз” сэдэвт симуляцийн сургалтыг төвийн бүсийн аймгуудаар олон салбарын төлөөллийг оролцуулан зохион байгуулна.	Олон улсын төсөл хөтөлбөр	Сургалтад оролцсон байгууллагын тоо Сургалтад хамрагдсан хүний тоо	-	Нэг эрүүл мэнд - Зооноз” сэдэвт симуляцийн сургалтыг төвийн бүсийн аймгуудаар олон салбарын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан байна.	“Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн санхүүжилтээр “Монгол Улсад нэг эрүүл мэндийн хандлага хэрэгжих таатай орчин бүрдүүлэх тухай” төслийн хүрээнд төвийн бүс, зүүн болон говийн бүсийн аймгуудад “Нэг эрүүл мэнд-Зооноз” сэдэвт дадлага, сургуулилалтыг зохион байгуулсан. Нэг эрүүл мэнд үзэл баримтлал нь хүн, амьтны эрүүл мэнд, экосистемийн нөхцөл, хүрээлэн буй орчныг тогтвортой тэнцвэржүүлж, оновчтой болгох замаар сайн сайхан байдлыг дэмжих, эрүүл мэнд, экосистемд учирч буй аюул заналхийллийг даван туулахад олон салбарууд хамтран ажиллах боломжийг бий болгохыг зорьдог. Ковид-19 цар тахлын сургамжаас бид Нэг эрүүл мэнд үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлыг шинэ шатанд гаргаж эрчимжүүлэх шаардлагатайг бүгд ойлгож ажил хэрэг болгохоор ажиллаж байгаагийн нэг нь энэхүү дадлага, сургуулилалт юм. 1. Төвийн бүсийн үзүүлэх сургуулилалтыг Архангай аймгийн Цэнхэр суманд 2023 оны 09 сарын 01-02-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан. Сургалтад МЭЕГ, ОБЕГ, ЗӨСҮТ, ХӨСҮТ, УМЭАЦТЛ, Мал эмнэлгийн хүрээлэн, НМЭГ,	

					<p>Нийсдэдийн ЗӨСТ, Төвийн бүсийн 8 аймгийн ЭМГ, ЗӨСТ, МЭГ, БОГ нийт 60 гаруй мэргэжилтэн оролцсон. Төвийн бүсийн хэмжээнд хэрэгжсэн хүн, мал эмнэлгийн хамтарсан тандалт, бусад зоонозын тулгамдсан асуудлаар мэдээллүүдийг хүргэсэн. Тэргүүлэх өвчнийг тогтоох, ширээний дадлага ажил, үзүүлэн танилцуулга гэсэн гурван хэсэг үйл ажиллагааг зохион байгуулсан.</p> <p>2. Зүүн болон говийн бүсийн үзүүлэх сургуулилалтыг Хэнтий аймгийн Чингис хотноо 2023 оны 10 сарын 25-26-ны өдрүүдэд дадлага, зохион байгуулсан. Энэхүү дадлага сургуулилалтаар зоонозын гаралтай хүний өвчлөлийн төлөв байдал, мал амьтны эрүүл мэнд, нэг эрүүл мэнд үзэл баримтлалын хүрээнд хэрхэн хамтарч ажиллах талаар мэдээлэл, санал солилцон, ширээний дадлага, сургуулилалт хийсэн. Дадлага сургуулилалтад ЭМЯ, БОАЖЯ, Хэнтий аймгийн ЭМГ, ЗӨСҮТ, МЭЕГ, ШУА-ийн Биологийн хүрээлэн, УМЭАЦТЛ, ХӨСҮТ, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Дорнод, Хэнтий, Говьсүмбэр, Сүхбаатар аймгийн ОБЕГ, МЭГ, ЭМГ, ЗӨСТ, НЭ зэрэг 13 байгууллагын 60 гаруй мэргэжилтэн оролцсон. Зүүн бүсийн хэмжээнд хэрэгжсэн хүн, мал эмнэлгийн хамтарсан тандалт, бусад зоонозын тулгамдсан асуудлаар мэдээллүүдийг хүргэсэн. Хэнтий аймгийн Баян-Адарга суманд Тарваган тахлын тохиолдол бүртгэгдэж, хээрийн эмнэлэг дэлгэсэн тухай дасгал сургуулилалтыг зохиомжийн дагуу зохион байгуулсан.</p> <p>3. Баруун бүсийн аймгуудын үзүүлэх дадлага, сургуулилалтыг Завхан аймгийн Улиастай суманд 2023 оны 11-р сарын 22, 23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус дадлага, сургуулилалтад Дэлхийн банк, ЗӨСҮТ, ХӨСҮТ, МЭХ, МЭЕГ,</p>
--	--	--	--	--	--

						УМЭАЦТЛ, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгийн ЗӨСТ, ЭМГ, НЭ, МЭГ, БОАЖГ-ын зэрэг 30 байгууллагын 50 гаруй мэргэжилтэн оролцсон. Тарваган тахлын хүний өвчлөлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг цогц байдлаар видео бичлэг бэлтгэн үзүүлэх сургалтыг зохион байгуулсан. Баруун бүсийн хэмжээнд хэрэгжсэн хүн, мал эмнэлгийн хамтарсан тандалт, бусад зоонозын тулгамдсан асуудлаар мэдээллүүдийг хүргэсэн.	
2.6	МУЗГҮАХ 1.1.3; Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал. 5.3.3 Зоонозын өвчний хариу арга хэмжээний талаар эрүүл мэндийн ажилтныг чадавхжуулна.	Олон улсын төсөл хөтөлбөр	Зохион байгуулсан сургалтын тоо Сургалтад хамрагдсан хүний тоо	21 аймгийн 129 сумын 15 байгууллагын 3000 эмч, мэргэжилтнүүд сургалтад хамрагдсан.	15 аймгийн 23 сумын 4000 эмч, мэргэжилтнүүд эд зоонозын өвчний хариу арга хэмжээний сургалтыг зохион байгуулсан байна.	Зоонозын халдварт өвчний талаар эрүүл мэндийн ажилтныг чадавхжуулах үйл ажиллагааны хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгууллаа. 1. 2023 онд 4 улсад 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 7 мэргэжилтэнг гадаад сургалтад хамруулж орчин үеийн анагаах ухаан, зоонозын халдварт өвчний тандалт оношилгооны дэвшилтэд арга зүйд сургаж, чадавхжуулсан. 2. 2022-2023 оны үндсэн мэргэшлийн сургалтад 3 мэргэжилтэн, төрөлжсөн мэргэшлийн сургалтад 7 мэргэжилтэн, дагалдан сургалтын хөтөлбөрт 10 мэргэжилтэн суралцаж төгссөнөөр Үндэсний төв болон орон нутгийн ЗӨСТ-үүдийн мэргэжилтнүүдийн чадавх болон мэргэшсэн хүний нөөцийн тоог нэмэгдүүлсэн. 3. Нийслэл, орон нутгийн ЗӨСТ-өөс биологич, амьтан судлалын болон шимэгч судлалын лаборант нийт 38 мэргэжилтнийг “Зоонозын өвчин дамжуулагч, шимэгч хорхой тодорхойлох арга зүйн чадавхийг сайжруулах” сэдэвт 5 өдрийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан. 4. "Зоонозын өвчний дархлаажуулалт, галзуу өвчнөөс сэргийлэх" цахим сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Сургалтад 21 аймгийн	100

					<p>БОЭТ, НЭ, ЭМГ, Сумдын ЭМТ, ЗӨСТ-үүд, Нийслэлийн 9 дүүргийн ЭМТ, Өрхийн эмнэлэг, ГССҮТ, Түргэн тусламжийн төвийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн, тархвар судлагч, вакциначор сувилагч, ЯТТ, гэмтэл, халдвартын тасгийн сувилагч нар хамрагдсан. Нийт 250 мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>5. Зоонозын өвчний төлөв байдал, зоонозын өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтын зохион байгуулалт, тарих арга техник, мэдээ тайлан гаргах сэдэвт сургалтад ХӨСҮТ-ийн сувилагч, Аймаг, дүүргийн ЭМГ-ын хүйтэн хэлхээний бага эмч, Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн сувилагч, хүлээн авах тасгийн тархвар судлалын вакцин тарьдаг сувилагч нийт 181 хүн хамрагдсан.</p> <p>6. Нийслэлийн эрүүл мэндийн газар болон Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд тарваган тахал өвчний тархвар судлал, хариу арга хэмжээ" баяр наадмын амралтын үеэр тохиолдол бүртгэгдсэн үед шуурхай хариу арга хэмжээний бэлэн байдал, Улаанбаатар хотод үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор "Үерийн дараах халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, анхаарах асуудлууд" сэдвээр сургалт зохион байгуулсан. Сургалтад 200 гаруй мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>7. Тарваган тахал өвчний улиралчлал эхэлж байгаатай холбоотой цахим сургалт 2 удаа зохион байгуулсан. Сургалтаар тарваган тахал өвчний хариу арга хэмжээг зохион байгуулахад халдвар хамгаалал-аюулгүй ажиллагаа, тархвар судлал, эмнэл зүй, эмчилгээ, оношилгоо, салбар хоорондын хамтын ажиллагааны талаар мэргэжил арга зүйн зөвлөмж өгсөн. Сургалтад нийслэл, аймгийн</p>
--	--	--	--	--	--

						<p>Зоонозын өвчин судлалын төвүүд, аймгуудын ЭМГ, БОЭТ, НЭ, сумдын ЭМТ, ЭХЭМҮТ, Улаанбаатар төмөр замын төв эмнэлэг, нийслэлийн яаралтай түргэн тусламжийн тасаг, Дүүргийн Нэгдсэн эмнэлгүүд зэрэг 300 гаруй байгууллагын 1250 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцсон.</p> <p>8. Азийн хөгжлийн банк, Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр “Нийслэл, аймгийн Зоонозын өвчин судлалын төвүүдэд молекул биологийн оношилгоог нэвтрүүлэх ажлын байран дахь сургалт”-ыг 14 аймгийн ЗӨСТ-ийн нийт 226 эмч, мэргэжилтэнд, “Нийслэл, аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн лабораторийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт”-ыг 14 аймгийн ЗӨСТ-ийн нийт 38 лаборант, ариутгагч нарыг хамруулан зохион байгуулсан.</p>	
2.7	<p>МУХТЖҮЧ 2.2.2; ЗГҮАХ 1.1.3.3; Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 8.2.2</p> <p>Зорилтот бүлгийн иргэдэд зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл, сурталчилгаа зохион байгуулна.</p>	Олон улсын төсөл, хөтөлбөр, ЭМДС	Цахимаар хүргэсэн мэдээлэл сургалт сурталчилгааны хандалтын тоо	<p>2022 онд зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 7 зөвлөмж, 30 инфографик, 4 видео бичлэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээсэн хандалт 14,920 байна.</p>	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	<p>Иргэд, олон нийтэд зонхилон тохиолддог зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл хүргэх үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгууллаа.</p> <p>Телевизийн ярилцлага:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Малчин, Eagle, МҮОНТ, ТМ, 25ТВ, SBN, Өлзий, TV9, NTV, Монгол, Тэнгэр, С1 14 телевизэд 54 удаа мэдээлэл хийсэн байна. <p>Радио ярилцлага:</p> <ul style="list-style-type: none"> ✓ МҮОНР болон MGL радиогоор эрүүл мэндийн нэвтрүүлэгт тус төвийн эмч, мэргэжилтнүүд оролцож малчид, ард иргэдэд 16 удаагийн мэдээлэл, зөвлөгөө, сэрэмжлүүлэг өгсөн байна. <p>Цахим хэрэгсэл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Цахим хуудас: 235 мэдээ нийтэлсэн. Нийт хандалт 228947 байна. 	100

					<p>✓ Фэйсбүүк хуудас: 482 мэдээ нийтэлсэн. Нийт хандалт 453761 байна.</p> <p>✓ Автомат хариулагч чатбот: Төвийн фэйсбүүк хуудасны мессенжерт 24/7 горимоор ажиллах “Хаяг, байршил”, “Ковид шинжилгээ”, “Дархлаажуулалт” гэсэн 3 дэд цэстэй автомат хариулагч /чатбот/ хийж гүйцэтгэсэн. Чатбот 24/7 горимоор ажиллаж, 137 иргэнд мэдээлэл хүргэсэн байна.</p> <p>Титр мэдээ:</p> <p>✓ МҮОНТ, 25 телевизүүд оргил цагаар зоонозын халдвар, галзуу, хачгаар дамждаг халдвараас сэргийлэх 9 мэдээ, мэдээллийг хүн амд хүргэсэн.</p> <p>Инфографик, постер:</p> <p>✓ Анзаарагддаггүй халдвар -3, Галзуу өвчин-27, Хачгаар дамждаг халдвар-7, Хумхаа –9, Тарваган тахал-10, Хүнсний аюулгүй байдлын дэлхийн өдөр-1, Боом-4, Хумхаа-7, Бэтэг-4 зэрэг нийт 72 инфографик шинээр боловсруулан цахим мэдээллийн хэрэгслээр хүн амд хүргэсэн.</p> <p>✓ Зоонозын халдварын зонхилон тохиолддог тарваган тахал, боом, бэтэг, хачгаар дамжих халдвар, хумхаа, галзуу зэрэг халдварын А5, А3 нийт 10 хэвлэлийн эх бэлтгэн нийт 5000 ширхэг хэвлэсэн.</p> <p>Масс мессеж:</p> <p>✓ Хачгаар дамжих халдвар, Галзуу, Боом, Тарваган тахал өвчний сэрэмжлүүлгийг үүрэн операторын G-mobile, Skytel, Mobicom нийт 636000 хэрэглэгчдэд масс мессежээр 5 удаа хүргэсэн.</p> <p>E-Mongolia төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системтэй хамтран гар утасны аппликейшнаар</p>
--	--	--	--	--	---

						тарваган тахал өвчний сэрэмжлүүлгийг иргэдэд хүргэсэн.	
2.8	МУХТЖҮЧ 2.2.2; ЗГҮАХ 1.1.3.3; Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 8.2.2 Зоонозын өвчинтэй тэмцэх дэлхийн өдрүүдийг угтсан аян зохион байгуулна.	Олон улсын төсөл, хөтөлбөр, ЭМДС	Тайлан	Төлөвлөгөөт ажлыг зохион байгуулсан.	Төлөвлөгөөт сургалт, сурталчилгаа бүрэн хийгдсэн байна.	<p>2023 онд Зоонозын өвчинтэй тэмцэх дэлхийн өдрүүдийг угтан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>“АНЗААРАГДДАГҮЙ ӨВЧНҮҮДИЙН ДЭЛХИЙН ӨДӨР”-ҮҮДИЙН ХҮРЭЭНД</p> <p>2023 оны 01 сарын 30-ны өдөр “Одоо хий, Хамтдаа ажилла, Анзаарагддаггүй өвчнүүдтэй тэмцэх үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хий” уриан дор анзаарагддаггүй өвчнүүдийн дэлхийн өдрийг зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ МҮОНТВ, МҮОНР-аар хүн амд анзаарагддаггүй өвчнүүдийн дэлхий дахинд болон Монгол Улс дахь өнөөгийн нөхцөл байдал, сэргийлэлт, хариу арга хэмжээний талаарх мэдээлэл хүргэсэн. ✓ Анзаарагддаггүй өвчнүүдийн мэдээлэл, 3 инфографик шинээр боловсруулан ЭМЯ, ДЭМБ, ЗӨСҮТ, www.news.mn, www.mnb.mn, www.otoch.mn, www. https://www.ulsturch.mn/ цахим хуудас болон мэдээллийн веб хуудаст нийтлүүлэв. <p>ХУМХАА ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ ДЭЛХИЙН ӨДӨР:</p> <p>2023 оны 04 сарын 25-нд “Хөрөнгө оруулах, инновац нэвтрүүлэх, хэрэгжүүлэх” уриан дор хумхаатай тэмцэх дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ “Монгол HD”, “Өлзий ТВ”-д зочны цагт нэвтрүүлэгт оролцон хүн амд хумхаа өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээлэл, зөвлөмж хүргэсэн. ✓ “Хумхаа өвчний тухай”, “Хумхаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэгдэх боломжтой”, “Өнөөдөр хумхаа өвчинтэй тэмцэх дэлхийн өдөр” зэрэг цуврал инфографик, мэдээлэл бэлтгэж байгууллагын веб, цахим хуудас, ЭМЯ, ДЭМБ, www.24tsag.mn, www.newspress.mn, 	100

					<p>www.mnb.mn мэдээллийн цахим хуудсаар мэдээлэл түгээж ажилласан.</p> <p>ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДЭЛХИЙН ӨДӨР: 2023 оны 06 дугаар сарын 07-нд “Хоол хүнсээр дамжих зоонозын халдвараас сэргийлье” сэдэвт мэдээлэл, постер бэлтгэн төвийн цахим хэрэгслээр хүн амд хүргэв.</p> <p>ГАЛЗУУ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ ДЭЛХИЙН ӨДӨР: 2023 оны 09 дүгээр сарын 28-нд Галзуу өвчинтэй тэмцэх Дэлхийн өдрийг “Нэг хүний эрүүл мэнд бол бүх нийтийн эрүүл мэнд, Бүх нийтийн эрүүл мэнд бол Нэг эрүүл мэндийн зарчимд тулгуурлана” гэсэн уриан дор тэмдэглэн өнгөрүүлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Цахим сургалт: 21 аймгийн Эрүүл мэндийн газар, Зоонозын өвчин судлалын төвүүдэд галзуу өвчний төлөв байдал, урьдчилан сэргийлэх, ЕБС-ийн сурагчдад мэдлэг олгох, галзуу өвчний эрсдэлд, өртсөн үед авах арга хэмжээ цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар цахим сургалт зохион байгууллаа. Сургалтад 98 эмч, мэргэжилтэн хамрагдсан байна. ✓ Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж нийслэл, аймгийн ЗДТГ-т албан бичгээр хүргүүлэв. ✓ Хэвлэл мэдээлэл: Монгол HD суваг телевиз, ЭМЯ-ны цахим хаягаар Албаны дарга Л.Роломжав, Биологич Ц.Баяр нар галзуу өвчний дэлхий дахинд болон Монгол Улсын нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэж, ЗӨСҮТ-ийн цахим хуудсаар тус өдөртэй холбоотой нийт 35 мэдээ, мэдээлэл, инфографик нийтэлсэн нийт 48454 хандалттай байв. ✓ Сургалт: Аймаг, нийслэл Зоонозын өвчин судлалын төвүүд галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг ерөнхий боловсролын 60 сургуулийн 7569 сурагчид, эрүүл мэндийн болон
--	--	--	--	--	---

						бусад байгууллагын 1437 ажилтан, иргэд олон нийтэд сургалт явуулж, 11200 ширхэг сэрэмжлүүлэх зөвлөмж, зурагт хуудас тарааж орон нутгийн телевиз, радио, фэйсбүүк зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан сургалт сурталчилгааны ажлыг идэвхтэй зохион байгуулж ажиллалаа.	
2.9	МУХТЖҮЧ 2.2.2; ЗГҮАХ 1.1.3.3; Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 8.2.2 Ховд, Увс, Баян-Өлгий аймгийн зарим сумдын хүн амд тарваган тахал өвчнөөс сэргийлэх компани ажил зохион байгуулах, үр дүнг үнэлнэ.	Олон улсын төсөл, хөтөлбөр	Тайлан	-	3 аймгийн хүн амын дунд төлөвлөгөөт сургалт, сурталчилгаа бүрэн хийгдсэн байна.	<p>Дэлхийн банкны санхүүжилтээр ЭМЯ-ны хэрэгжүүлж буй “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн хүрээнд “Алслагдсан орон нутагт амьдарч буй иргэдийг цар тахлын урьдчилан сэргийлэлт, хяналтын талаарх чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ”-г танилцуулах цахим уулзалтыг Дэлхийн зөн монгол ОУБ-аас зохион байгуулж буй төслийн үйл ажиллагааны албан ёсны нээлт хийх үйл ажиллагаанд оролцсон.</p> <p>Цахим уулзалтад Дэлхийн банкны санхүүжилтээр ЭМЯ-ны хэрэгжүүлж буй “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төсөл хэрэгжүүлэх нэгж, Баян-Өлгий, Ховд аймгуудын удирдлагууд, ажлын хэсэг, хамтрагч байгууллагууд, ИНБ-ын төлөөлөл оролцлоо. Төсөл батлагдаж, 2023 оны 11 сараас 6 сарын хугацаатай хэрэгжихээр шийдвэрлэгдсэн.</p> <p>Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний хүрээнд Баян-Өлгий, Ховд, Увс, аймгуудад дуудлагын багийн бүрэлдэхүүнийг тушаалаар томилж, тарваган тахал өвчнөөс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, захирамж батлуулан хариу арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Увс, Ховд аймгийн 18 сумын 1530 хүнээс тарваган тахал өвчний хүн амын дундах судалгаа авсан.</p>	80

						Баян-Өлгий аймагт тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023.08.16-ны өдрөөс эхлэн аймгийн төвөөс гарах 6 чиглэлд хөдөлгөөнт эргүүл хяналтыг өдөр бүр холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулан ажилласан. Хяналтын цэгт ажиллах болон хөдөлгөөнт эргүүлийн үеэр нийт 1100 гаруй тээврийн хэрэгслийг шалгаж, 1600 орчим ард иргэдэд тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээлэл өгч 700ш санамж хуудас тараав.	
2.10	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.3.2 Хээрийн тандалт судалгаанд шаардлагатай тоног төхөөрөмж, жижиг хэрэгслийн багцаар хангана.	Олон улсын төсөл хөтөлбөр	Хангалт хийсэн багцын тоо	-	Хангалт хийж хээрийн тандалт судалгаа хийсэн байна.	АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй МОН-9218 төслийн нэгжээс зоонозын халдварын хээрийн тандалт судалгаанд зориулсан 133 сая төгрөгийн 16 нэр төрлийн тоног төхөөрөмж, жижиг хэрэгсэл бүхий тандалт судалгааны багаж тоног төхөөрөмж, Дэлхийн банкны CS02 тоот гэрээний “Монгол Улсад Нэг эрүүл мэндийн хандлага хэрэгжих таатай орчин бүрдүүлэх тухай” төслийн хүрээнд хээрийн эмнэлэгт хэрэглэгдэх 35 сая төгрөгийн тандалт судалгааны багц мөн НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр аюултай хог хаягдлын сав, тусгай зориулалтын сав хээрийн тандалт судалгаанд зориулан тус тус нийлүүлсэн. Ингэснээр зоонозын халдварт өвчний тандалт судалгааг өргөжүүлэх, цаг, уур амьсгалын өөрчлөлттэй холбон судлах боломж бүрдсэн.	100
Зорилт 3. Лабораторийн лавлагаа тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, чадавхийг бэхжүүлэх							
3.1	Төвийн дотоод хяналтын сорилтын лаборатори нь MNS ISO/IEC 17025:2018 буюу “Сорил болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага”-ыг хангах	608.000 мян.төг (Улсын төсөв)	Батлагдсан төлөвлөгөө	-	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Төвийн дотоод хяналтын сорилтын лаборатори нь MNS ISO/IEC 17025:2018 буюу “Сорил болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага”-ыг хангах бэлтгэл ажлын хүрээ стандарт заавартай танилцаж шаардлагатай бичиг баримтуудыг судалж байна. 2023 оны 11-р сарын 12-16-ны хооронд Катар, Доха, Мал эмнэлгийн лабораториудад ISO17025	100

	ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.					стандартын хэрэгжилт, засвар үйлчилгээ хийхэд iVetNet-ийг ашиглах бүсийн сургалтад хамрагдсан. QR кодыг ашигласнаар лабораторийн Албаны дарга болон Чанарын менежер лабораторийн дотоод үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг тухай бүр хянаж холбогдох мэдээллийг цаг алдалгүй шинэчлэх, доголдол үүссэн тохиолдолд засвар үйлчилгээг хийлгэх боломж бүрэн нээгдэж байна.	
3.2	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал. 6.5.3 SARS-CoV2, хачигт риккетсиоз өвчний үүсгэгчийн геномын бүрэн дараалал тодорхойлох судалгааны ажил хийнэ.	Олон улсын төсөл, хөтөлбөр	Судалгааны ажлын тайлан	NGS аппаратыг суурилуулж, эмч мэргэжилтнийг сургасан байна.	SARS-CoV2, хачигт риккетсиоз өвчний үүсгэгчийн генотип, полиморфизмын судалгааг хийсэн байна.	“Next Generation Sequence ISEQ -100 төхөөрөмжийг бүрэн ажиллагаанд оруулах, Зоонозын халдварт өвчний үүсгэгчийн гений дараалал тодорхойлох” сургалт ДЭМБ-тай хамтран хэрэгжүүлж байна. 1. NGS төхөөрөмжийг ажиллагаанд оруулах зорилгоор Ковид-19 эерэг 8 сорьцоос цомгийн зааврын дагуу РНХ ялгаж, секвенсийн ПГУ болон цэвэршүүлэлт хийж, секвенсийн дата дүн дээр анализын программаар боловсруулалт хийсэн 2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгээр ЗӨСҮТ-ийн молекул биологийн лабораторид хадгалагдаж байгаа 2023 оны тандалтын хачигнаас хачигт риккетсиоз эерэг тодорхойлогдсон 24 хачгийн булингыг сонгон авч Сингапурын мэргэжилтэн Fajar Muhamed-тай хамтран OmpB, SCsa1 генийн бүтэн дарааллыг тодорхойлов. Мөн Сингапур Улсын illumina сургалтын төвд 3 мэргэжилтэн NGS microbiology сургалтад хамрагдсан.	100
3.3	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 6.5.4 “Эс өсгөвөрлөх” судалгааны ажил хийнэ.	-	Судалгааны ажлын тайлан	-	Эс өсгөвөрлөх аргыг нэвтрүүлэх судалгааны ажлын тайлан гарсан байна.	2023 онд хачигт энцефалит оноштойгоор нас барсан 2 хүний 10 эмгэг судлалын материалыг УТ-ПГУ, б.ц УТ-ПГУ-аар шинжилж эерэг тодорхойлогдсон 6 сорьцыг ВНК-21 эсэд халдварлуулж эс гэмтээх үйлчлэлийг	90

						тодорхойлсон ба үр дүнгээр судалгааны ажлын тайлан бичсэн.	
3.4	Шимэгч судлалын лабораторид ISO 15189 стандартыг нэвтрүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	-	Батлагдсан төлөвлөгөө	-	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Шимэгч судлалын лабораторийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор төлөвлөгөө боловсруулан ажилласан. Төлөвлөгөөний биелэлт 100%. - Магадлан итгэмжлэлд ISO 15189 нэвтрүүлэх ажлын хүрээнд хачгийн судалгааны стандарт ажиллагааны зааврыг Мал эмнэлгийн хүрээлэнгийн Паразит судлалын лабораторийн гарын авлагатай уялдуулан боловсруулж байна. - Стандартыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, зардал тооцох зэрэг сэдвүүдээр сургалт мэдээлэл хийсэн - Бүүрэгний зураг авах, бүүрэг тодорхойлох бичиг орчуулах ажлууд хийгдээд байна.	50
3.5	“Алсын хараа-2050” 2.2.28; ЗГҮАХ 2.1.8.7; Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 6.5.6 Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл авна.	-	Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	292 нэр төрлийн химийн бодисын жагсаалтыг гаргаж төвийн Ерөнхий захирлаар батлуулсан.	Химийн хорт болон аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрөл БОАЖЯ-наас авсан байна.	СХД-ийн Засаг даргаас Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулахаар 11 төрлийн бичиг баримтын бүрдүүлэлт хийж дүгнэлт гаргуулан авсан. 1. “Мон эко газар” ХХК-иар байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хийлгэсэн. 2. БОАЖЯ-нд Байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэх албан хүсэлт явуулсан. 3. Төсөл хэрэгжих газрын байршлын зургийг Мон эко газар” ХХК-иар гаргуулсан. 4. Тус төвд ашиглагдаж буй 292 нэр төрлийн химийн бодисын жагсаалтыг гаргаж ерөнхий захирлаар батлуулан хор аюулын лавлах мэдээллийг бичиж 2992 хуудас материалыг бэлдсэн. 5. Төслийн үйл ажиллагаанд шаардлагатай химийн бодисын хэрэгцээ шаардлага, галын аюулгүй дүгнэлт, эмнэлгийн аюултай хог хаягдлын гэрээ, УСУГ гэрээ, хөрсний шинжилгээ, 2022 онд худалдан авалт хийсэн	80

						<p>тендерийн гэрээ гэх мэт баримт бичгийг бүрдүүлж БОАЖЯ-д emongolia-аар илгээсэн.</p> <p>6. БОАЖЯ-ны 2023 оны 05 сарын 01-ний 12/2397 тоот албан бичгээр Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргуулж авсан. Үүний дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэж 200 хуудас бүхий тайланг СХД-ийн 20-р хорооны Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон.</p> <p>7. Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийн эрүүл ахуйн хязгаарлалт, хориглолтын бүстэй тус тус давхцаагүй болохыг БОАЖЯ-ны 2023 оны 05 сарын 16-ны 06/2742 16/253 тоот албан бичгээр авсан.</p> <p>8. Тайланг СХД-ийн 20-р хорооны Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж, хурлын протоколыг “Мон эко газар” ХХК-д илгээсэн. Бүх материалыг БОАЖЯ руу цахимаар илгээсэн.</p>	
3.6	Биоаюулгүй байдлыг хангах урт хугацааны хөтөлбөр боловсруулахад чиг үүргийн хүрээнд оролцоно.	-	Албан журмаар хүргүүлсэн санал	-	Хөтөлбөрт саналууд тусгагдсан байна.	<p>2023 онд ДЭМБ-ын олон улсын шинжээчид томилон зохион байгуулдаг ОУЭМД-ийн үнэлгээнд Био аюулгүй ажиллагаа ба биохамгаалал хэсгийн Р7.1, Р7.2-т үнэлгээг хийлгэсэн.</p> <p>Үндэсний “Биологийн зэвсгийн конвенцийн хүрээнд үндэсний хууль тогтоомжийг хэлэлцэх” семинарт оролцож, төс төвөөс хэрэгжүүлж буй био аюулгүй ажиллагааны бодлого төлөвлөлтийг танилцуулж, Үндэсний аюулгүй байдлын Ажлын албаны референтүүд тус төвд ирж цаашдын бодлого төлөвлөлтийг танилцуулж, шийдвэрийн төслийг хүргүүлсэн.</p>	100
Зорилт 4. Зоонозын өвчний байгаль дахь тархалт, идэвхжлийг хянах, хүн амын дундах тархалт, эрсдэлийн түвшин тогтоох тандалт судалгааг өргөжүүлэх							

4.1	МУХТЖҮЧ 2.2.1; ЗГҮАХ 2.1.1; МУХТ 1.3.1; Эрүүл мэндийн салбарын стратеги төлөвлөгөө - Зорилт 2.1 "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 төлөвлөгөө"-г хэрэгжүүлнэ.	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2022 онд төлөвлөгөө 90% биелсэн.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө батлах тухай" тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ЭМЯ-нд сар, улирал, хагас жилээр хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангуудыг 2023 оны 1а/621, 1а/651, 1а/673 тоот албан бичгүүдээр илгээсэн. 2023 онд хөтөлбөрийн хэрэгжилт 100% байна.	100
4.2	"Алсын хараа- 2050" 2.2.39; МУХТЖҮЧ 2.2.6; Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал. 5.3.3 Зоонозын өвчний бүртгэл мэдээллийн программыг ЗӨСТ-үүдэд нэвтрүүлнэ.	-	Программ хангамжийг бүрэн нэвтрүүлсэн ЗӨСТ-ийн тоо	Зоонозын өвчний мэдээллийн систем Үндэсний төвд бүрэн нэвтэрсэн.	Программ хангамжийг 15 аймгийн ЗӨСТ-ийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн байна.	Зоонозын өвчний мэдээллийн систем (ZIS) программыг системийн хэмжээнд 14 ЗӨСТ-үүдэд бүрэн нэвтрүүлж (208 мэргэжилтэн бүртгэгдсэн), программын ашиглалт, хэвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, гарсан алдаа, дутагдлыг тухай бүрд нь залруулж ажилласан. ZIS прораммын гарын авлага боловсруулж хэвлэлтэд өгсөн.	100
4.3	Баян-Өлгий аймгийн Ногооннуур, Улаанхус, Бугат сумдын нутагт тарваган тахал өвчний тандалт судалгааг хийж, голомтот нутгийн төлөв байдлыг тогтооно.	ОХУ-ын хөтөлбөрийн санхүүжилт	Тандалт судалгааны тайлан	Тарваган тахал өвчний байгалийн голомт хяналтын тандалт судалгааг 321.000 га талбайд хийж гүйцэтгэн тайлан бичигдсэн.	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.	ОХУ-ын Эрхүү хотын Тарваган тахал эсэргүүцэн судлах эрдэм шинжилгээний хүрээлэн, Горный Алтайн Тарваган тахал эсэргүүцэн судлах станц, Баян-Өлгий аймгийн ЗӨСТ-ийн мэргэжилтнүүдтэй хамтран Монгол-Алтайн нурууны Сийлхэмийн бүлэг голомтын хил орчмын 43 секторт хамрагдах 361000 га талбайд тарваган тахал өвчний тандалт шинжилгээг хийж гүйцэтгэлээ. Шинжилгээнд 354 нэгж материал хамруулснаас алтайн тарвага-8, урт сүүлт зурам-4, монгол огдой-3, дагуурын огдой-1, өмхий хүрэн -1, мэрэгч амьтдын зэм үхдэл-313, гадны шимэгч-14, шувууны гулгидас-10 тус бүр лабораторийн шинжилгээнд хамруулаа. Нян судлалын шинжилгээний дүнд Ногооннуур (7), Улаанхус Өртөөн булаг (5) Ногооннуур Борхаг (3), Бугат Хөндий (2), Улаанхус Терсагкан (1), Улаанхус Сонгинот (1), Ногооннуур Агуйтын булаг (1) зэрэг газруудаас олзворлосон тарваганы сэг зэмээс	100

						тарваган тахлын 20 өсгөвөр илрүүлж, голомтыг тогтоогоод байна. Энэ нь дээрх нутгуудад сэг зэмийн тоо, өсгөврийн тоо нэмэгдэж байгаа нь цаашид эпизотийн талбай тэлэх хандлагатай байгааг харуулж байна.	
4.4	Увс аймгийн Сагил, Бөхмөрөн сумдын нутагт тарваган тахал өвчний тандалт судалгааг хийж голомтот нутгийн төлөв байдлыг тогтооно.	ОХУ-ын хөтөлбөрийн санхүүжилт	Тандалт судалгааны тайлан	Тарваган тахал өвчний байгалийн голомтын тандалт, хайгуул шинжилгээг 151200 га талбайд хийж гүйцэтгэн тайлан бичигдсэн.	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.	Увс аймгийн Бөхмөрөн, Сагил сумдын нутагт 17 секторын 153000 га талбайд Увс аймгийн ЗӨСТ, ОХУ-ын Эрхүү хот дахь Сибирь, Алс дорнодын Тарваган тахал эсэргүүцэн судлах эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран 2023 оны 07 дугаар сарын 17-ноос 07 дугаар сарын 30-ны хооронд тарваган тахал өвчний байгалийн голомтын төлөв байдлыг тогтоох тандалт, хайгуул шинжилгээ хийлээ. Тандалт судалгаагаар 27 монгол тарвага, 43 монгол огдой, 27 урт сүүлт зурам, 1 бор туулай нийт 98 амьтан олзворлож, үс ноолуураас нь 14 зүйлийн 263 бүүрэг, 1 зүйлийн 11 хачиг цуглуулав. Нийт 17 секторт хайгуул хийснээс Зэнхлэг-Гашуун 3154606234-аас 1 бүтэн үхдэл, Хавчуу 3154606141-гаас махчин шувууны хоолны үлдэгдэл мөн 13 сектороос шинэ 2 сэг зэм, хуучин 104 нийт 108 сэг зэм цуглуулав. Лабораторийн шинжилгээнд 98 мэрэгч, туулай хэлбэртэн амьтан, тарваганы үхдэл, сэг зэм 107, үений сэг зэм-1, бүүрэг-274, хачиг-11 нийт 496 материал цуглуулан хээрийн лабораторийн шинжилгээнд хамруулсан. Лабораторийн шинжилгээг ИХА, ПГУ-аар хийхэд эерэг хариутай материал илрээгүй.	100
4.5	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.2.5 Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт токсоплазм өвчний байгалийн голомт, хүн	Олон улсын төсөл хөтөлбөр	Тандалт судалгааны тайлан	2022 онд Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, Дархан-Уул аймагт эмнэлэгт суурилсан тандалт судалгаа	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.	Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт токсоплазм өвчний хүн амын дундах тандалт судалгааг зохион байгуулж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1. Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр сумын малчид, мал бүхий иргэдээс токсоплазмоз өвчний тархвар судлалын холбогдолтой сорьц (цусны	100

	амын дундах тандалт судалгаа хийнэ.			хийж тайлан бичигдсэн.		ийлдэс 62) цуглуулан халдварын тархалтыг тогтоох ажил хийгдэж байна. 2. Токсоплазмоз өвчний мэдлэг, дадал, хандлагыг тодорхойлох асуумж 70-ыг авав. 3. Тандалт судалгаанд хамрагдсан хүн амын дунд токсоплазмоз өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар 17 удаа яриа хийж, 54 хүнд сурталчилгаа хийсэн. 4. Токсоплазмоз, өвчнөөс урьдчилан сэргийлэх санамж 140-ыг тарааж ажилласан.	
4.6	“Алсын хараа- 2050” 2.2.1; МУЗГҮАХ 2.1.6; Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал. 5.2.2 Сэлэнгэ аймгийн нутагт хачигт риккетсиоз өвчнөөр өвчилсөн хүмүүст эмнэл зүйн үлдцийн судалгаа хийнэ.	Олон улсын төсөл хөтөлбөр	Судалгааны ажлын тайлан	Булган, Сэлэнгэ аймагт хачигт энцефалит, хачигт боррелиоз, хачигт риккетсиозоор батлагдсан хүмүүсийн дунд эмнэл зүйн үлдцийн судалгаа хийж, судалгааны ажлын тайлан гарсан.	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.	Сэлэнгэ аймагт сүүлийн 20 жилд хачигт риккетсиоз өвчнөөр дунд, хүндэвтэр, хүнд явцтай өвчилсөн 20 хүнд үлдцийн судалгаа хийхэд Нугасны Гэмтлийн, Халууралтын, менингитийн хэлбэрээр өвчилсөн байсан. Үүнээс: 1. Нугасны гэмтлийн хэлбэрийн үед толгой өвдөнө 1 удаа унасан. толгой өвдөнө сонсгол буурсан. толгойгоо даахдаа сул баруун гар хөл сул саатай, 2 гар мэдээгүй, хүзүүний булчин сул хатангиршилтай 4 хүн байна. 2. Халууралтын хэлбэрийн үед толгой өвддөг даралт ихэсдэг. Хааяа хөл гар бадайрна, юм мартана А/Д ихэснэ толгой өвдөнө, хичээлдээ сайн сурдаг, толгой өвддөг 6 хүн байна. 3. Менингитийн хөл гарын булчин сул бадайрна юм мартана, хааяа толгой өвддөг, хөл гар бадайрдаг, бөөр усажсан, толгой өвдөнө сонсгол буурсан 6 хүн байна. 4. Шинж тэмдэг үлдэц зовуурьгүй 5 хүн байна. Мөн судалгааг үргэлжлүүлэн хийж байна.	100
						Дорнод аймгийн Гурванзагал, Дашбалбар, Чулуунхороот, Баяндун, Баян-Уул сумдын нутагт хачгаар дамжих халдварын тандалт судалгааг хийсэн. Байгалийн голомтын судалгаагаар цуглуулсан D.nuttalli зүйлийн 97 хачгийн зүйл	

4.7	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал. 5.1.2</p> <p>Дорнод аймгийн Баяндун, Баян-Уул суманд хачгаар дамжих халдварын байгалийн голомт, хүн амын дундах тандалт судалгаа хийнэ.</p>	<p>Жорж Мэйсоны Их Сургууль АНУ</p>	<p>Тандалт судалгааны тайлан</p>	-	<p>Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.</p>	<p>тодорхойлж ганцаарчилсан лабораторийн шинжилгээнд хамруулснаас 40.8% хачигт риккетсиоз, 24.5% бартонеллөз өвчний үүсгэгчийн өвөрмөц ДНХ-г агуулсан байна. 5 сумдад бартонеллиозын халдвар, Чулуунхороот, Гурванзагал сумдад риккетсиозын халдвар хачгийн дунд орчин байгааг шинээр тогтоолоо.</p> <p>Хүн амын дундах тандалт судалгаагаар цуглуулсан 82 цусны ийлдэснээс 35% нь хачигт риккетсиоз, 23% хачигт энцефалит, 19% нь хачигт боррелиоз, 19% нь анаплазмоз, 4% нь эрлихиозийн өвөрмөц эсрэгбие IgG тус тус тодорхойлогдсон. Дорнод аймгийн хойд бүсийн (Баяндун, Баян-Уул, Дашбалбар, Чулуунхороот, Гурванзагал) сумуудад хачгаар дамжих түгээмэл болон анзаарагддаггүй халдварын тархалт ажиглагдаж байна. Мөн хачигт халдварын талаарх иргэдийн мэдээлэл хангалтгүй, иргэдийн дунд хачиг хазсан үед зөв салгаж авах арга техник дутмаг байгаа нь иргэдэд хачигт халдварын талаар мэдээлэл хүргэх, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.</p>	100
4.8	<p>ХХААХҮЯ, Мал эмнэлгийн ерөнхий газар, Мал эмнэлгийн хүрээлэнтэй хамтран Сэлэнгэ, Дархан-Уул, Булган аймгийн 6 сумын нутагт шинэ болон сэргэн тархаж байгаа халдварын тандалт судалгаа хийнэ.</p>	-	<p>Олон улсын төсөл хөтөлбөр</p>	<p>УМЭАЦТЛ, МЭХ-тэй хамтран 2008-2012 онуудад хамтарсан тандалт судалгааг улсын хилийн дагуух бүх сумдын нутагт хийж, тандалт судалгааны тайлан бичигдсэн.</p>	<p>Хамтарсан тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.</p>	<p>Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори хамтран Төвийн бүсийн Булган аймгийн Тэшиг, Хутаг-Өндөр, Сэлэнгэ аймгийн Түшиг, Цагааннуур, Дархан-Уул аймгийн Орхон, Дархан сумдад анзаарагддаггүй халдваруудын тандалтыг 2023 оны 05 сарын 10-25-ны өдөр хийж гүйцэтгэлээ. 3 аймгийн 6 сумын 9 цэгийн 24 км газарт дарцаг тавьж бэлчээрээс 63, малаас 5 нийт 68 хачиг цуглуулсан. Хүн амын дундах тандалт судалгаанд 3 аймгийн 6 сумын нийт 97 хүнийг хамрууллаа. Хачгаар дамжих халдварын эрсдэлт бүхий нийт 65 хүнээс цусны ийлдэс цуглуулж лабораторийн шинжилгээнд хамрууллаа.</p> <p>Тандалт судалгааны үр дүнд:</p>	100

						Судалгаанд хамрагдсан нутагт хус, шинэсэн холимог уулын ойт хээр, алаг өвст, залаат ургамал бүхий уулын хээрт 2 зүйлийн хачиг (<i>I.persulcatus</i> , <i>D.nutallii</i>) тархсан байна. Бэлчээрийн хачгийн 1 дарцаг/км-т ногдох тоошил 2.63, нэг малд ногдох тоошил 0.2 байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 9.8% нь хачигт эрлихиозийн, 19.5% нь Ку чичрэгийн, 7.3% нь бабезиозын, 7.3% нь хачигт боррелиозын, 24.4% нь хачигт энцефалитын халдваржилтайг тогтоогдлоо.	
4.9	Дорнод аймгийн Халхгол суманд шумуул, хархаар дамжих халдварын байгалийн голомт, хүн амын дундах тандалт судалгаа хийнэ.	-	Тандалт судалгааны тайлан	-	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.	Ялалт багийн нутаг дахь Буйрын застав түүний орчим, Баянхошуу боомт орчим, Бурхантын застав, сумын төв, Нөмрөг, Хар хоньтын заставт бор хархны тандалт судалгааг 45000 га талбайд хийж гүйцэтгэлээ. Халхгол сумын төвийн айлуудаас 4 харх, Мөнхтал ХХК-ий тариа бригадын агуулах 22 харх шинжилснээс бие гүйцсэн 82%, залуу 9%, төл 9% эзэлж байна. Бие гүйцсэн бодголь 1 эрд 2 эм бодгаль оногдож байгаа нь үржил эрчимтэй явагдах нөхцөлийг бүрдүүлсэн байлаа. Мөн 5 цэгт газраас 1200 шумуул цуглуулан лабораторид иммунохроматограпийн аргаар нийт 70 сорьцод шинжилгээ хийхэд 1 сорьцод <i>f.tularensis</i> эерэг тодорхойлогдсон.	100
4.10	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.1.4 НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцогчдод хумхаа өвчний тохиолдлын судалгаа хийж, сургалт зохион байгуулна.	Олон улсын төсөл хөтөлбөр	Тандалт судалгааны тайлан Зохион байгуулсан сургалтын тоо Сургалтад хамрагдсан хүний тоо	-	Хумхаа өвчний голомтот нутагт энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцдог цэргийн албан хаагчдад танхимын болон цахим сургалт зохион	Зэвсэгт хүчний жанжин штабтай хамтран “Хумхаа өвчнөөс урьдчилан сэргийлье” сэдэвт сургалт зохион байгуулж, хумхаагийн голомтот нутагт энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцон эх орондоо ирсэн бие бүрэлдэхүүн болох 873 хүнийг хамруулан эрт илрүүлэг шинжилгээ хийж гүйцэтгэлээ. Урьдчилсан шинжилгээнд хамрагдсан эрсдэлт бүлгийн бие бүрэлдэхүүнээс цуглуулсан шинжилгээний сорьцод хумхаа өвчний тохиолдол бүртгэгдээгүй.	100

					байгуулсан байна.		
4.11	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.2.3 Шувууны томуу өвчний байгалийн голомтын эрсдэлийн мэдээллийн сан үүсгэнэ.	-	Хүргүүлсэн мэдээний тоо	-	Шувууны томуу өвчний байгалийн голомтын тандалт судалгааны тоо мэдээг нэгтгэж холбогдох байгууллагад мэдээлсэн байна.	"Дэлфи" мэдээллийн санг шувууны томуугийн цар тахалтай тэмцэх, чадавхийг сайжруулах төслийн хүрээнд 2011 онд гаргасан. Энэхүү мэдээллийн санд Ховд, Хөвсгөл, Баянхонгор аймгийн ЗӨСТ-ийн шувууны ажиглалтын мэдээг нэгтгэж байна. EpiCollect5 утасны аппликейшин ашиглан орон нутгийн ЗӨСТ-ийн шувууны ажиглалтын мэдээг авч байна. Шувуу хамгаалах төв, Зэрлэг амьтан хамгаалах төвтэй хамтран шувууны тандалт судалгааг хийж байна. 2023 онд Шувуу хамгаалах төвтэй хамтран хиймэл 5000 үүрний 200 идлэг шонхор шувуудад шинжилгээ хийсэн. 200 идлэг шонхрын арчдас бүгд сөрөг дүнтэй гарсан. Дэлхий дахинд болон манай оронд бүртгэгдсэн шувууны томуугийн 14 хоног тутмын мэдээ орчуулж бэлтгэж 13 дугаарын мэдээг бэлтгэн цахим хуудсанд байршуулан иргэд олон нийт болон салбар хоорондын байгууллагуудад мэдээлэл хүргэх үйл ажиллагааг тогтмолжууллаа.	100
4.13	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.2.4 Холер, боом өвчний хяналтын шинжилгээний үр дүнд үнэлгээ хийнэ.	-	Тандалт судалгааны тайлан	-	Холер, боом өвчний хяналтын шинжилгээний үр дүнд үнэлгээ хийсэн байна.	Холерын хяналтын шинжилгээнд сорьц авах хуваарь гарган батлуулж, 4 удаа шинжилгээ хийсэн. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй холерийн халдварын эрсдэлд өртөж болзошгүй 12 байгууллагын 33 цэгт газраас нийт 152 сорьц цуглуулан лабораторид суурилсан тандалтыг хийсэн. Лабораторийн шинжилгээгээр холерийн үүсгэгч илрээгүй. Шинжилгээний хариуг холбогдох газруудад нь 4 удаа утсаар болон 26/402, 26/418, 26/450 тоот албан бичгээр тус тус эргэн мэдээлэв. 2023 оны ЗӨСҮТ-ийн Захирлын А/54 дүгээр тушаалын дагуу "Боомын хяналтын шинжилгээг" Улаанбаатар хотод 7 удаа зохион байгуулж эрсдэл бүхий 12 байгууллагад хийгдсэн. Шинжилгээнд байгууллагын онцлогоос хамаарч махны лангуу,	100

						мах, махан бүтээгдэхүүн бэлтгэлийн төхөөрөмжүүд, түүхий эд зөөдөг тэрэг зэргээс 149ш арчдас мөн 6ш ноос, 10ш арьс, шир дээжинд нян судлалын шинжилгээ хийсэн ба боомын үүсгэгч тодорхойлогдоогүй.	
4.14	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.1.1 Баян-Өлгий аймгийн тарваган тахал өвчний байгалийн голомтын өндөр идэвхтэй Цагааннуур, Улаанхус сумдын нутагт мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэл хийж, үр дүнг үнэлнэ.	Орон нутгийн төсөв	Мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэл хийсэн талбайн хэмжээ	Баян-Өлгий аймгийн Ногооннуур, Улаанхус сумын суурьшлийн бүсэд мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэл хийсэн.	Төлөвлөсөн бүс нутагт мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийг хийж, үр дүнг хянасан байна.	2023 оны 07 дугаар сарын 17-ноос эхлэн 2023 оны 08 дугаар сарын 11-нийг хүртэл 24 хоног ЗӨСҮТ, Баян-Өлгий аймгийн ЗӨСТ болон ОХУ-ын Эрхүү хотын Тарваган тахал эсэргүүцэн судлах эрдэм шинжилгээний хүрээлэн, Горный-Алтай мужийн Тарваган тахал эсэргүүцэн судлах станцын мэргэжилтнүүдээс бүрдсэн баг Баян-Өлгий аймгийн Улаанхус сум, Ногооннуур сум, Бугат сум болон Цэнгэл сумын хил орчмын бүс болох Сийлхэмийн голомтод тарваган тахлаас урьдчилан сэргийлэх байгалийн голомтыг хянах, идэвхийг тогтоох хамтарсан тандалт судалгааг хийж үр дүн, зөвлөмжийг аймгийн ЗДТГ, ЭМГ-т хүргүүлсэн. Зоонозын өвчин судлалын үндэсний төв болон БНХАУ-ын Амьтан судлалын олон улсын нийгэмлэг (ISZS) хооронд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж дараах чиглэлээр хамтран ажиллахаар болов. Үүнд: 1. Тарвага, бусад мэрэгчид болон бүүрэгний элбэгшил, тархалтын судалгаа хийх 2. Тарвага, бусад мэрэгчдээр халдварлах тахлын эрсдэлийг бууруулах бэлдмэлийн туршилт хийх 3. Тахлын тархалтыг мэрэгчид болон бүүрэгний элбэгшилтэй зэрэгцэн хянах 4. Сургалт зохион байгуулах	100
Зорилт 5. Эрдэм, шинжилгээ судалгааг хөгжүүлэх							
						“Зоонозын халдварын тулгамдсан асуудлууд” Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Улаанбаатар хот,	

5.1	<p>“Зоонозын халдварын тулгамдсан асуудлууд” Олон улсын эрдэм шинжилгээний 24 дэх удаагийн хурлыг зохион байгуулна.</p>	<p>Улсын төсөв, Олон улсын төсөл хөтөлбөр</p>	<p>Оролцсон байгууллага, илтгэл өгүүлэл, судлаачдын тоо</p>	<p>Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2021 онд зохион байгуулсан.</p>	<p>Оролцогч байгууллага, эрдэм шинжилгээний илтгэл өгүүлэл, судлаачдын тоог нэмэгдүүлсэн байна.</p>	<p>Нийслэлийн онцгой байдлын газрын хурлын танхимд амжилттай зохион байгууллаа. “Зоонозын халдварын тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах ажлын хэсэг болон Редакцийн зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны төлөвлөгөөг төвийн Ерөнхий захирлын 2023 оны А/06 дугаар тушаалаар баталж, хэрэгжүүлэн ажиллаа. Тус олон улсын эрдэм шинжилгээний хуралд ЭМЯ, ДЭМБ-ын Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар, ЗӨСҮТ, Мал эмнэлгийн ерөнхий газар, Мал эмнэлгийн хүрээлэн, АШУҮИС, ХААИС, ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвүүд, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв болон ОХУ-ын Эрхүү хот дахь Роспотребнадзорын Тарваган тахал эсэргүүцэн судлах эрдэм шинжилгээний хүрээлэн, Гэр бүлийн эрүүл мэнд, хүний нөхөн үржихүйн асуудлын эрдэм шинжилгээний төв, Саратов хот дахь Роспотребнадзорын тарваган тахал эсэргүүцэн судлах эрдэм шинжилгээний «Микроб» хүрээлэн, Новосибирск хот дахь Холбооны суурь ба хавсрага анагаах ухааны судалгааны төв, БНХАУ-ын Хятадын өвчний хяналт сэргийлэлтийн төв, Хөх хотын Олон улсын аялал жуулчлалын эрүүл мэндийн төв зэрэг гадаад, дотоодын 20 орчим байгууллагын 100 гаруй төлөөлөгчид оролцсон “Зоонозын халдварын тулгамдсан асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хуралд Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд найрамдах Хятад ард улс, Америкийн нэгдсэн улс, Казакстан Улсын мэргэжлийн байгууллагын судлаач, эрдэмтдийн олон жилийн судалгааны үр дүнг нэгтгэсэн нийт 48 бүтээл ирүүлснээс 16 илтгэлийг амаар, 12 илтгэлийг ханын илтгэл хэлбэрээр хэлэлцүүлж, 48</p>	100
-----	---	---	---	---	---	---	-----

						бүтээлийн Монгол, Англи хувилбар бүхий хураангуйн эмхэтгэлийг хэвлүүллээ.	
5.2	“Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл”-ийн 2023 оны 5 (112) дугаарыг эрхлэн гаргана.	-	Хэвлүүлсэн илтгэл өгүүллийн тоо	2022 оны 4-р дугаарын хэвлүүлэн түгээсэн.	Салбарын эрдэмтэн, судлаачдын судалгаа, шинжилгээний ажлын үр дүн олны хүртээл болсон байна.	Эрдэм шинжилгээний бүтээл нийтлүүлэх зарыг Зоонозын өвчин судлалын байгууллагуудын хэмжээнд түгээж, мэдээлэл цуглуулан, ХӨСМС-ийн редакциар хянуулж “Тоонот принт” ХХК-ий хэвлэлийн үйлдвэрт 100 хувийг хэвлүүлж, нийтийн хүртээл болгож ажиллаа. Үр дүн: Эрдэм шинжилгээний өгүүлэл-3, Тойм өгүүлэл-1, Эпоним-1, Товч мэдээ, ажиглалт-4-ийг сэтгүүлийн редакциар хянуулж батлуулан, нийтлүүллээ.	100
5.3	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх эмч, мэргэжилтнүүдтэй гэрээ байгуулж, цалин урамшуулалтай холбож олгоно.	-	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан Хэлэлцүүлсэн, хэвлүүлсэн илтгэл, өгүүлэлийн тоо	Төвийн захирлын 2017 оны А/01 тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.	Төвийн эмч, мэргэжилтнүүд ийн судалгааны ажил гүйцэтгэх идэвх, санаачлаг нэмэгдсэн байна.	ЗӨСҮТ-ийн Ерөнхий захирлын 2017 оны 01 сарын 24-ий өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан “Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гэрээгээр гүйцэтгэх журам”-ын хүрээнд ЗӨСҮТ-ийн 5 судлаач судалгааны ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаа. Судалгааны ажлын гүйцэтгэлийг хагас, бүтэн жилээр дүгнэн төвийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох урамшууллыг олгож ажиллалаа. Үүнд. 1. Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын алба (НЭМТШУА)-ны Амьтан судлагч Д.Батжав “Монгол орны тарваган тахал өвчний байгалийн голомтын орон зайн тархалт ба түүний онцлог” 2. Ариутгал, халдваргүйтгэл, био үйлдвэрлэлийн албаны Биотехнологич Б.Батцэцэг “Тоосруулан хуурайшуулах төхөөрөмжид шингэн тэжээлт орчин хуурайшуулж, бүтээгдэхүүний чанарыг физик, хими, микробиологийн аргуудаар шалгах нь” 3. НЭМТШУА-ны Шимэгч судлаач Ц.Ганхуяг “Тарваган тахал өвчний үүсгэгч илэрсэн бүүрэгний зүйлийн бүрдэл, тархалтыг тогтоох” 4. Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн албаны Статистикч эмч	100

						<p>О.Даариймаа “Монгол Улс дахь хачигт боррелиозын тархалт, тархвар зүйн онцлог”</p> <p>5. НЭМТШУА-ны Тархвар судлагч эмч Ш.Сувд-Эрдэнэ “Сонгогдсон сумдын хачгаар дамжих зарим халдваруудын байгалийн голомтын тархалт, хүн амын дундах мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх нь” тус тус гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Гэрээ байгуулсан 5 судалгааны ажлын хүрээнд 5 мэргэжилтэн үндсэн цалингийн 20 хувиар, 2 мэргэжилтэн үндсэн цалингийн 15 хувиар тус тус урамшуулалд хамрагдсан.</p>	
Зорилт 6. Төвийн удирдлага, зохион байгуулалт, засаглалыг сайжруулах							
6.1	Төвийн дунд хугацааны 2023-2026 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулна.	-	Батлагдсан стратеги төлөвлөгөө	-	Төвийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө” батлагдан хэрэгжиж эхэлсэн байна.	ЗГХЭГ-ын Даргын 2020 оны 100 дугаар тушаал дагуу “Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөө”-г 4 ерөнхий чиг үүрэг, 6 үндсэн чиг үүрэг, 22 дэд чиг үүрэг, 7 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан ЭМЯ-ны хариуцсан мэргэжилтэнтэй 3 удаагийн уулзалт хийж, өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу засварлан боловсруулж, төвийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Эрзүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажуулахаар хүргүүлээд байна.	90
6.2	Зоонозын удирдах зөвлөгөөн байгуулна.	салбарын ажилтны зохион	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	-	Зоонозын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулсан байна.	Зоонозын өвчин судлалын байгууллагуудын Удирдах ажилтны ээлжит зөвлөгөөнийг 2023 оны 03 сарын 22-ны өдөр “Лабораторийн тусламж, үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх нь” зорилтын хүрээнд зохион байгуулсан. Уг зөвлөгөөнөөр Нийслэл болон 21 аймгийн ЭМГ, ЗӨСТ-ийн нийт 40 гаруй мэргэжилтнүүд оролцон орон нутаг дахь зоонозын халдварт өвчний оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцүүлсэн. Тус зөвлөгөөнд ЭМЯ-ны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, тус газрын Ахлах мэргэжилтэн А.Долгорханд нар оролцлоо.	100

						<p>Зөвлөгөөнөөр зоонозын салбарын сүүлийн 10 жилийн ололт амжилтаа дүгнэж, дараагийн 10 жилийн хөгжлийн чиг хандлагаа тодорхойлон, тулгамдаж буй асуудлуудаа шийдвэрлэх арга замыг хэлэлцсэн. Энэхүү зорилтын хүрээнд мэргэшсэн, ёс зүйтэй мэргэжилтнийг бэлтгэх, тэдний цалин, нийгмийн хамгааллын асуудлыг Эрүүл мэндийн багц хуулиудад нэмэлт заалтуудыг оруулах замаар шийдвэрлэх, анхан шатны түвшинд лабораторийн чадавхийг нэмэгдүүлэх, лабораторийн сүлжээг боловсронгуй болгох, ЗӨСТ-үүдийн шинэ барилгыг үе шаттайгаар барих зэрэг бодлогын томоохон асуудлуудыг хэлэлцэхээс гадна лабораторийн тусламжийн чадавхийг бэхжүүлэх, тандалт судалгааг нотолгоонд суурилан төлөвлөх асуудлаар багаар ажиллах дадлага сургалтад хамрагдсан.</p>	
6.3	<p>ЗГҮАХ 2.1.5.4 , Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 тоот албан даалгавар Эрүүл мэндийн ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг боловсронгуй болгож, цалин урамшуулалтай холбож олгоно.</p>	-	<p>Батлагдсан гүйцэтгэлийн шалгуур Гүйцэтгэлийн шалгуурын дагуу цалин урамшууллыг олгосон шийдвэр</p>	<p>Төвийн ерөнхий захирлын 2021 оны А/11 дүгээр тушаалаар баталсан журам хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.</p>	<p>Гүйцэтгэлийн шалгуур шинээр батлагдаж, ажилтнуудын цалин урамшууллыг гүйцэтгэлийн шалгуурын дагуу олгосон байна.</p>	<p>Төвийн Ерөнхий захирлын 2021 оны А/11 дүгээр тушаалаар батлагдсан журмыг боловсронгуй болгох зорилгоор нийт ажилтан албан хаагчдаас санал авч, Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн 2023 оны А/38 дугаар тушаалаар журмыг шинэчлэн баталсан. Уг журмаар нийт ажилтан, албан хаагчдад олгох үр дүнгийн мөнгөн урамшуулал, ур чадварын нэмэгдэл, мөн оны шилдэг ажилтан шалгаруулах үнэлгээний шалгуурыг илүү боловсронгуй болгож, мөрдлөг болгон ажиллаж байна. Уг журмаар ажилтан, албан хаагчид сар, улирал бүр хийж гүйцэтгэсэн ажлын тайланг тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлүүлэн, үнэлгээний дүнг цалин урамшуулалтай уялдуулж байна. Төвийн ерөнхий захирлын 2023 оны А/38 дугаар тушаалаар ажилтнуудад олгох үр дүнгийн мөнгөн урамшуулал, ур чадварын нэмэгдэл, мөн оны</p>	100

						шилдэг ажилтан шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулж мөрдлөг болгон ажиллаж байна. ✓ “Мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу улирал бүр ажилчдын ажлыг дүгнэн, нэгдсэн үнэлгээг Удирдлагын зөвлөлийн хурлаар 4 удаа хэлэлцүүлж, шийдвэр гаргуулан давхардсан тоогоор 350 гаруй ажилтанд 111,630,000 гаруй сая төгрөгийн урамшуулал олгосон байна. ✓ “Ур чадвар олгох журам”-ын дагуу сар бүр ажилчдын ажлыг дүгнэн, нэгдсэн үнэлгээг Удирдлагын зөвлөлийн хурлаар 11 удаа хэлэлцүүлж, шийдвэр гаргуулан давхардсан тоогоор 980 гаруй ажилтанд 115,440,00 гаруй сая төгрөгийн урамшуулал олгосон байна.	
6.4	Төвийн ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батална.	-	Шинэчлэн баталсан албан тушаалын тодорхойлолтын хувь	-	Нийт ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/305 дугаар тушаалаар төвийн бүтэц, дүрмийг шинэчлэн батлуулсан. Тус төвийн бүтцийн өөрчлөлттэй уялдуулан төвийн 110 ажлын байрны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, удирдлага, ажилтан гарын үсэг зурж баталгаажуулсан.	100
6.5	МУХТЖҮЧ 2.2.8; ЗГҮАХ 2.1.9.5 Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлж тайлагнасан.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Эрүүл мэндийн ажилтны Нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төвийн эмч, ажилтнуудын нийгмийн хамгааллыг дэмжих төлөвлөгөөг Ерөнхий захирлаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласан. “Тэтгэврийг хөнгөлттэй нөхцөлөөр тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар “Хэлт энд Сэфти Солушинс” ХХК-иар ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг үнэлгээ хийлгэж, дүгнэлтэд үндэслэн саналыг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.	100

						<p>Мөн эмч, ажилтнуудыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, журмын дагуу тусламж, урамшуулалд хамруулах ажлуудыг зохион байгуулсан бөгөөд шинэ ажилтныг журмын дагуу сонгон шалгаруулж, байгууллагад дасан зохицох хөтөлбөр боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Төвийн эмч, ажилтнуудын нийгмийн хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөөний 100 хувь биелэлттэй байна.</p>	
6.6	<p>Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 тоот албан даалгавар</p> <p>Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.</p>	Улсын төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2022 онд	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	<p>Энэ онд Төвийн дэргэдэх Ёс зүйн салбар хорооны бүрэлдэхүүн томилогдсон 3 жилийн хугацаа дуусгавар болж Ёс зүйн салбар хороог 2023 оны 03 дугаар сард журмын дагуу шинэчлэн байгуулсан.</p> <p>Төвийн дэргэдэх Ёс зүйн салбар хороог шинэчлэн батлах тухай Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 11 дүгээр тогтоол гарч, уг тогтоолын дагуу Төвийн захирлын 2023 оны Б/51 дүгээр тушаалаар хорооны бүрэлдэхүүнийг томилон, баталгаажуулсан. Уг хороо нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нийт 5 гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.</p> <p>Ёс зүйн салбар хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 бүлэг 19 үйл ажиллагаатай батлуулан ажилласан бөгөөд 100% биелэлттэй байна.</p>	100

6.7	<p>Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 тоот албан даалгавар</p> <p>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.</p>	Улсын төсөв,	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2022 онд төлөвлөгөө боловсруулан 100% хэрэгжүүлсэн.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	<p>Тус төв нь үйлчлүүлэгчгүй боловч нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын онцлогд тохируулан шинээр ажилд орсон ажилтан албан хаагчидтай авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ярилцлага хийж, санал солилцсон. Мөн удирдах албан тушаалд шинээр томилогдсон 3 албан тушаалтны ХАСУМ-ийг АТГ-аар хянуулан, зөрчилгүй дүгнэлттэйгээр албан тушаалд томилсон. Байгууллагад авлига ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, хүнд суртал, шударга бус байдал гаргахгүй байхыг сурталчилсан “Үгүй гэж хэлээд өөрчилье” контент бүтээж байгууллагын албан ёсны веб сайт болон цахим хуудсаар дамжуулан сурталчилсан. https://www.youtube.com/watch?v=VvqXWEKFGIs</p> <p>Мөн нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлига ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг бууруулах зорилгоор гарын авлага бэлтгэн, хэвлэж төвийн ажилтан, албан хаагч болон орон нутгийн Зоонозын өвчин судлалын төвүүдэд тараасан. Мөн орон нутгийн төвүүдийг контент болон гарын авлагыг олон нийтэд тараах, сурталчилахыг зөвлөсөн. Тус төв нь авлигын эсрэг аянд нэгдэж байгууллагын мэдээллийн самбар, албан ерөөний хаалга зэрэгт зурагт хуудсыг нааж, авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан.</p>	100
6.8	МУХТЖҮЧ 2.2.6 Төвийн үйл ажиллагаа, мэдээ, мэдээллийг цахимжуулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Зоонозын халдварт өвчний бүртгэл мэдээллийн системийг	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	<p>Зоонозын өвчлөлийн мэдээллийг ZIS программд хүний өвчлөлийн бүртгэл, мэдээллийг бүрэн оруулсан эсэхэд өдөр бүр нэвтэрч, хяналт тавьж, мэдээллийн бүрэн бүтэн байдалд 6 удаа тулгалт хийж, хамтарч ажиллалаа. ZIS программ хангамжийн бүртгэл мэдээлэл 100 хувьтай явж</p>	100

				нэвтрүүлж эхэлсэн.		байна. Нийт ZIS программд бүтгэгдсэн 616 хүний өвчлөлийн дуудлагын төлөвийг ангилбал батлагдсан 118, үгүйсгэгдсэн 197, шинжилгээнд байгаа 264, бүртгэгдсэн 37 тохиолдол байна.	
6.9	ЗГҮАХ 2.1.7.5 Төвийн тусламж, үйлчилгээний нэгж өртгийг тооцно.	-	Өртөг тооцсон тусламж, үйлчилгээний тоо	2022 онд биоүйлдвэрлэ лийн үйл ажиллагааны нэгж өртгийг тооцоолон гаргаж, нэгж бүтээгдэхүүний үнийг шинэчлэн тогтоосон.	Зонхилон тохиолдох зоонозын өвчний лабораторийн шинжилгээний нэгж өртгийг тооцсон байна.	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” 49/А/118 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтыг үндэслэн Төвийн захирлын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/11 дүгээр “Төлбөртэй шинжилгээ үйлчилгээний жагсаалт батлах тухай” тушаалд заасан тарифаар хувийн аж ахуй нэгжүүдийн хүсэлтийн дагуу төлбөртэй шинжилгээг хийсэн. Нийт 43.6 сая төгрөгийн орлого олсон. Яаралтай дуудлагад бүртгэгдсэн зоонозын халдварын лабораторийн шинжилгээг үнэ төлбөргүй хийж баталгаажуулан хүргүүлж ажилладаг. Яаралтай дуудлагад ирдэг зонхилон тохиолдох өвчлөлүүдийн нэг болох тарвагад лабораторийн шинжилгээ хийх ажлын өртгийн тооцоог хийхэд 1 тарваганд лабораторийн шинжилгээ хийхэд 215.8 мянган төгрөгийн өртөгтэй. 2023 онд нийт 1115 тарвагад 240.6 сая төгрөгийн өртөгтэйгөөр лабораторийн шинжилгээ хийж ажилласан. 2023 оны нийт төсвийн 40 хувийг зоонозын халдварын лабораторийн шинжилгээний тусламж үйлчилгээнд зарцуулж байна.	100
6.10	Байгууллагын санхүүгийн удирдлагыг үр ашигтай хэрэгжүүлж, өр авлагагүй ажиллана.	-	Өр авлагын хэмжээ	Өр авлага байхгүй	Өр авлагагүй ажилласан байна.	Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/39 дүгээр тушаалын дагуу төвийн 2023 оны батлагдсан төсвийг 2,916.1 сая төгрөгөөр баталсан. Энэ нь 2022 оны батлагдсан төсвөөс - Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 16% - Хангамж бараа материалын зардал 60% - Нормативт зардал 4%	

						<ul style="list-style-type: none"> - Эд хогшил урсгал засварын зардал 56% - Томилолтын зардал 50% - Бусад зардал 82% тус тус хасагдсан. <p>2023 оны хагас жилийн санхүүгийн тайлангаар 59.9 сая төгрөгийн өр төлбөртэй тайлан гарсан. Энэ нь дээрх зардлууд өмнөх оноос хасагдаж батлагдсантай холбоотой болно. Иймд асуудлыг тухай бүр нь ЭМЯ-нд танилцуулж, дутагдаж буй санхүүжилтийг авах хүсэлтүүдийг тавьж ажилласны үр дүнд Эрүүл мэндийн сайдын сайдын 2023 оны 09 сарын 29-ний өдрийн А/349 дүгээр тушаалаар 3,519.7 сая төгрөг буюу оны эхний төсвөөс 603.6 сая төгрөгийн санхүүжилт нэмж авснаар 2023 оны төсвийн гүйцэтгэлийн 11 сарын зарлагын мэдээгээр өр авлагагүй тайлан гаргаж лабораторийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ хэвийн явуулж ажилласан.</p>	100
6.11	<p>Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01, 02 тоот албан даалгавар</p> <p>Тусламж, үйлчилгээний халдварын хяналт, сэргийлэлт, биоаюулгүй ажиллагааг сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.</p>	-	Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Халдварын хяналт, сэргийлэлт, биоаюулгүй ажиллагааг тогтмол хэрэгжүүлдэг.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	<p>Дэглэмийн багийн бүрэлдэхүүнийг шинээр Төвийн Ерөнхий захирлын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан. Халдварын сэргийлэлт хяналт, био аюулгүй ажиллагааны дэглэмийн багийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 14 үйл ажиллагааг тусгаж 100% хэрэгжүүлэн ажиллалаа.</p> <p>2023 онд шинээр ажилд орсон мэргэжилтнүүдийн судалгааг гарган нийт 19 ажилтанд “Шинээр томилогдсон ажилтнуудад халдвар хамгааллын дэглэм, халдвараас сэргийлэх хяналтын мэдлэг олгох сургалт”-ын хөтөлбөрийн дагуу 2 удаа зохион байгуулж ерөнхий мэдлэг, лабораторийн үйл ажиллагааг биечлэн танилцуулсан. Мөн сургалтын үр дүнг тооцох зорилгоор сургалтын өмнөх болон дараах мэдлэг шалгах сорилыг 16 асуултаар авсан.</p> <p>Харьяа орон нутгийн 14 ЗӨСТ-ийн мэргэжилтнүүдээс “ЗӨСТ-ийн халдвар хамгаалал</p>	100

					<p>биоаюулгүй байдлын үйл ажиллагааг үнэлэх шалгуур"-аар лабораторийн үйл ажиллагаа, халдвар хамгааллын багийн үйл ажиллагаа, биоаюулгүйн кабинет, гарын эрүүл ахуйн нөхцөл, хувийн хамгаалах хувцас хэрэгсэлд үнэлгээ хийн дүгнэсэн. Нэгдсэн дүнг цахим сургалтаар хэлэлцүүлэн мэдээлэл өгсөн.</p> <p>“Монгол Улсад үйлдвэрлэгдсэн антибиотик эмэнд нянгийн тэсвэржилт, идэвх тодорхойлох” туршилт, судалгааны явцад 2 удаа хяналт хийж илэрсэн зөрчлийн талаар илтгэх хуудсыг зөвлөмжийн хамт өгсөн.</p> <p>“Шинээр томилогдсон ажилтнуудад халдвар хамгааллын дэглэм, халдвараас сэргийлэх хяналтын мэдлэг олгох сургалтын хөтөлбөр”-ийн дагуу сургалтад нийт 19 ажилтан хамруулж сургалтыг зохион байгуулсан.</p> <p>“Ариутгал судлал”-аар мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-ний дагуу “Зоонозын халдварт өвчний үед ажиллах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийг мөрдөх, хэрэгжүүлэх”, “Хамгаалах өмсгөл өмсөж, тайлах дараалал”, “Халдварт өвчний голомтод баримтлах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагаа” сэдвүүдээр 26 цагийн онол дадлагын хичээл заасан.</p>	
--	--	--	--	--	--	--

Хэрэгжилтийн хувь:

97

2023 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 52 ажил төлөвлөн хэрэгжүүллээ. Үүнээс:

- Үр дүнтэй-зорилтот, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн - 46
- Тодорхой үр дүнд хүрсэн-зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарсан цаашид хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай- 4
- Эрчимжүүлэх шаардлагатай –зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх - 2

Үр дүнгүй – Зорилтот түвшиндээ хүрээгүй арга хэмжээ -0

Төлөвлөгөөг хянасан:
Эрүүл мэндийн сайд
(албан тушаал)

Тэмдэг

Төлөвлөгөө Тайлагнасан:
**Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
захиралын албан үүргийг хавсран гүйцэтгэгч**
(албан тушаал)

Тэмдэг

/...../
(гарын үсэг)

.....
(огноо)

/...../
(гарын үсэг)

.....
(огноо)